



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/120

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Олон угсаатны соёлын өвийг өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах, тэдний билиг авъяасыг иргэд нийтэд таниулах, тэднийг дэмжих, өвлүүлэн үлдээх зорилгоор зохион байгуулагдах “Олон угсаатны өв соёл-бидний бахархал” соёлын биет бус өв тээгчдийн Анхдугаар зөвлөлдөх уулзалтын зардалд 1,690,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулагдах 1,690,000 төгрөг (Нэг сая зургаан зуун ерөн мянга)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.5-д тусгагдсан “Олон үндэстэн ястны өв соёл урлаг” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 10-ны өдрийн
А/120 дугаар захирамжийн хавсралт



ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Зарцуулагдах төсөв /мянган төгрөгөөр/
1	Өргөмжлөл	Ш	17	20.000	340.000
2	Дагалдах мөнгөн шагнал	Ш	17	50.000	750.000
3	Цайны зардал	Ш	100	5.000	600.000
Нийт					1.690.000

-oOo-